



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2015 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 428

Улаанбаатар хот

Г “Денежный магнит” хадгаламж, зээлийн
хоршооны тусгай зөвшөөрлийг сунгах тухай Г

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ын 9.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Денежный магнит” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтанд холбогдох гэмдэглэгээг хийлгэж, хувийг 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Денежный магнит” ХЗХ /Т.Батдорж/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, холбогдох өөрчлөлтийг Хорооны бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДЭД ДАРГА

Э.БАТБОЛД

